

Living the Lotus 12

Buddhism in Everyday Life

2023
VOL. 219



Их Британи РКК

Living the Lotus Vol. 219 (2023.12)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami
-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Үргэлж эрч хүчтэй, эрүүл саруул Өвчин, зовлон бүгд сайн анд нөхөр Мунхаг сэтгэлийг тогтоон барих тухай

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Гамшигтай тулах үед...зоригтой нүүр тулах”

Шагжамүни бурханы гэгээрэлд хүрсэн өдөр болох 12 сарын 8 ныг сүсэгтэн бид тэмдэглэн, талархалаа илэрхийлэн “Бурхан багшийн гэгээрсэн өдрийн арга хэмжээ”-г зохион байгуулдаг. Энэ өдөр бүгдээрээ Шагжамүни бурханы айлдсан сургаал номтой учирсны гайхамшиг, талархалыг чин сэтгэлээсээ дахин нэг тунгаан бодоцгооё.

1828 оны ижилхэн 12 сарын 8 ны Бурхан багшийн гэгээрлийг олсон өдрөөр Зэн урсгалын их багштан Рёокан Шагжамүни бурханы гэгээрсэн үнэн номыг “амьд сургаал” хэмээн дурдсан нэг захидлыг том хэмжээний газар хөдлөлтөнд өртсөн найздаа бичин илгээж байсан түүхтэй.

Тэрхүү захиандаа “нүүр тулсан үхлээс мултарч, амьд үлдэх нь үлдсэн зовлонг туулж гарах сорилттой тулгарах тул эсрэгээрээ хэцүү даваа” хэмээн эхлээд найзынхаа зовлон шаналалыг тайтгаруулсны дээр “гэхдээ” хэмээн үргэлжлүүлээд, “гамшигтай тулах үедээ зоригтой нүүр тулж, үхэлтэй тулах үедээ зоригтой нүүр тулах хэрэгтэй. Энэ нь бидний зовлонгоос гэтэлгэх жинхэнэ сургаал бөлгөө” гэж зөвлөсөн байдаг. Гамшигаас гадна төрөх, өглөх, өвдөх, үхэхийн зовлонгоос энэ хорвоогийн хэн ч зугтах боломжгүй. Хүний хүчээр шийдэх боломжгүй, давагдашгүй хүчин зүйл нь юу ч хийгээд нэмэргүй тул байгаа чигт нь хүлээн авах нь тэрхүү зовлон зүдгүүрт нухлуулалгүй өнгөрөх цорын ганц арга зам юм, хэмээн хэлжээ.

“Гамшигтай тулах үедээ зоригтой нүүр тулж” гэдэг үг нь өнгөц сонсоход хүйтэн хөндий үг шиг санагдаж болох ч би энэ үгийг харж, дуулах бүртээ яасан үнэн хүчтэй үг вэ хэмээн, сэтгэл санаа онгойдогоо нуух юун. Үнэнийг дамжуулж хэлэх сэтгэлийн хат болон үгнээс нь мэдрэгдэх энэрэл нигүүлсэл, түүнчлэн тэр үгийг нь дааж хүлээж авах оюуны чадамжтай найз (номын анд) тэр хоёрын хоорондын итгэлцлийн харилцааг хараад сэтгэл хөдлөхгүй байхын аргагүй.

Эрүүл саруул, амгалан тайван амьдрах гэдэг нь ийм сэтгэлээр өдөр бүрийг талархал дүүрэн өнгөрүүлэхийг хэлэх болов уу.

Гагцхүү “бодь сэтгэлийг хөгжүүлэх” хэрэгтэй

Цагаан Лянхуа сударт “Дэвадат нь сайн анд нөхөр” гэсэн нэг мөрт байдаг. Дэвадат нь Шагжамүни бурханы шавь бөгөөд хамаатан боловч Шагжамүниг хороохыг завдсан хүн юм. Шагжамүни нь тэр хүнийг “сайн анд нөхөр” гэж хэлснийг ---Үүсгэн байгуулагч дараах байдлаар тайлбарлажээ. “Амьдралтай яаж нүүр тулах ёстой вэ гэсэн том асуултын хариуг өгсөн, нүдийг нээж өгсөн найз”. Мөн Киото дахь Зэнрин сүмийн ахлах лам Ёокан (1033–1111он) “өвчин нь жинхэнэ сайн анд мөн” гэж хэлсэн байдаг. “Ядарч сульдсан өөрийг нь аварсан, үнэн хуулийг ойлгох шалтгаан болсон ачтан бол өвчин минь байсан” хэмээх талархалын сэтгэлийг энэ мөртөөс харж болно.

Тэгэхээр байгалийн гамшиг ч тэр, өвчин ч тэр нүүр тулахад зугтмаар дайжмаар болдог нь энгийн л зүйл. Гэхдээ эдгээрийг хорвоогийн жам хэмээн хүлээн авч, сайн анд нөхөр гэж бодож чадвал зовлон зүдгүүрт нухлуулах нь битгий хэл, харин ч тайван амгалан байж, нугаралгүй урагшлах билиг оюуныг эзэмших болно гэсэн үг юм.

Түүнчлэн эрүүл мэнд ба өвчин гэдгийг эсрэг тэсрэг зүйл гэж бодох хүн байдаг. Үхэл, амьдрал нь зоосны хоёр тал лугаа байдаг шиг хүн эрүүл саруул байсан болохоор өвчинтэй нүүр тулж, өвчинтэй болсон болохоор эрүүл саруул байхын ач тусыг мэдэрдэг. Өөрөөр хэлбэл “өвчин ч гэсэн эрүүл мэндийн нэг хэсэг” гэсэн утгатай юм.

Энэ жилийн 1-р сарын дугаарт бид бүхэн мөн чанартаа эрүүл саруул, эрч хүчтэй оршихуун гэж дурдсан. Гэвч эдгээр зүйлсийг нэгтгээд харвал бид бүхэнд эрүүл саруул, эрч хүчтэй бие сэтгэлийг байгалаасаа заяасан бөгөөд хааяа өвдөж, ядрах үе байлаа ч түүнийгээ амьдрах хүч болгох чадвар бидэнд давхар заяагдсан гэсэн үг юм.

Нэг хүн “сэрүүн үедээ хийх ёстой зүйлээ бүх чадлаа дайчлан хийх, тэгээд орой бат бөх унтах” энэ бол эрүүл байхын нууц гэж хэлсэн байдаг. Энэ үгийн цаад утга нь хүн өөрийнхөө хийх ёстой зүйлээ хичээнгүйлэн хийвэл, байгалаасаа заяагдсан “амьдрах эрч хүч” сэргэдэг гэсэн үг юм. Үүний дээр бидний хувьд илүү чухал зүйл бол шунал, уур хилэнгээ давж, эвтэй сэтгэлээр өдөр бүр сургаал номондоо шамдах нь бодь сэтгэлийг хөгжүүлж буй явдал юм.

Шинээр угтах жилээ илүү эрч хүчтэй өнгөрүүлэхийн тулд бид бүхэн Шагжамүни бурханы сургаалыг сониуч сэтгэлээр дахин нягталж, миний бичсэн ном зохиол болон өөр эх сурвалжуудаас суралцаж, “бодь сэтгэлээ хөгжүүлэх” талаар тунгаан бодъё үзье.

<Косей> 2023 оны 12-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Үсэн доторх эрдэнэсийн сургаалт зүйрлэл

Нэгэн улсын хаан тулалдаанд гавьяа байгуулсан хүнд алт эрдэнэс өгч шагнадаг байжээ. Гэхдээ хаан үсэндээ зангидсан эрдэнийн зүйлээ л хэнд ч өгдөггүй бөгөөд тэрхүү эрдэнэс нь үнэтэй нандин бас авсан хүн нь зовлонд унадаг учиртай байв. Гэсэн хэдий ч хаан эцэст нь маш том гавъяа байгуулсан хүнд эрдэнэсээ өгчээ.

Шагжамүни бурхан ч гэсэн хүмүүсийн сургаалыг ойлгох түвшин дээшлэх үед нь Цагаан Лянхуа судрыг анх номлосон. Энэ нь Цагаан Лянхуа судар хамгийн дээд сургаал бөгөөд үүнийг ойлгохын тулд багаас нь суралцах сстойг сургаж буй юм.



Бяцхан мэдлэг

“Цагаан Лянхуа судар”-ын “Амар амгалан явахуйг үгүүлэх 14 бүлэг”-т өгүүлсэнчлэн хааны тэрхүү үнэт эрдэнэс бол Цагаан Лянхуа судрын сургаал юм. Мөн хаан нь Хүрд эргүүлэгч ариун хаан хэмээх бүх дэлхийг шударгаар захирдаг домогт гардаг хаан юм.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Сайн эмчийн сургаалт зүйрлэл



үхсэн гэж хэлсэн нь эмийн үр нөлөө (= сургаал)-нд итгэдэггүй хүүхдүүд (= хамаг амьтад)-ээ аврах (= бурханд ойртуулах) арга зам нь байжээ.

Бяцхан мэдлэг

Цагаан Лянхуа судрын “Түүнчлэн ирсэн нэгний амьдрал хэмээх 16 бүлэг”-т өгүүлсэнчлэн бурхан бидний амыг хүчээр нээн эм уулгадаггүй. Өөрөөр хэлбэл, сүсэг бишрэл нь бидэнд идэвхтэйгээр эрж хайн, олж авахын чухлыг сургаж байдаг.

Нэгэн өдөр алдартай эмч аавыгаа эзгүй байх үед хүүхдүүд нь хортой эм уучихжээ. Аав нь гэртээ хариад хүүхдүүдэд хорыг арилгах эм өгдөг ч хорны улмаас эрүүл ухаанаа алдсан хүүхдүүд нь уудаггүй. Ингээд аав нь эмээ орхиод аян замд гарч, элчийг гуйн өөрийгөө нас барсан гэж мэдээ хүргүүлдэг. Үүнийг сонссон хүүхдүүд ухаан орж, эмээ уун аврагдсан гэдэг.

Аав (= бурхан) нь үнэндээ үхээгүй мөртлөө

Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК, удаах ерөнхийлөгч
Нивано Коошоо

Бүх л хүүхдүүдэд

Амралтын өдрийн өглөө ариун цэврийн өрөөгөө цэвэрлэж байтал, дунд ба бага охидууд босчихсон, чанга дуугаар хоорондоо ярьсаар ариун цэврийн өрөөнд орж ирлээ. Тун ч сонирхолтой зүйлийн тухай ярьж байгаа бололтой.

“Өглөөний мэнд. Өглөөнөөс эхлээд юуны тухай ингэтлээ ярьна вэ” гэхэд

“Бид хоёр ... хүүгийн талаар ярьж байсан юм. Гадаа тоглож байхад аймаар хүчтэй ирж мөргөдөг, тэгчихээд юу ч хэлэлгүй яваад өгдөг. Бөмбөгөөр цохьчихоод ч уучлалт гуйдаггүй.” “тэгээд байхаар гадаа тоглохоос айх юм”

“Манай ангийн А байна ш дээ, хичээл дундуур дандаа чанга дуу гаргадаг. Аяархан байгаач гэхээр бүр чанга дуу гаргаад, ерөөсөө чимээгүй болдоггүй.” “харандаагаа түр хэрэглүүлэхээр, үзүүрийг нь хугалчихаад юу ч хэлдэггүй гээд боддоо”, “ширээн дээрх зүйлсийг байнга унагаадаг”

“Эрэгтэй хүүхдүүд яагаад ийм бүдүүлэг байдгийн болоо”

Тэр яриаг нь сонсоод би бага ангийнхаа дээрэлхүү хүүг хараад айдаг байснаа санаж, “тийм хүүхдүүд аймаар шүү тээ”, “сагсуу хөвгүүд хэцүү шүү тээ” гээд тэр хоёрын яриаг дэмжих маягтай сонсож байв.

Гэтэл охидуудын ярианы өнгө аяс өөр чиг лүү хэлбийж эхлэв. “А байна ш дээ. Угаасаа замбараагүй тэнэг үстэй тээ”, “царай нь ч гэсэн дээ авах юмгүй”, “зан ааш нь ч гэсэн” гэх зэргээр.

Тэр үед би охидуудаасаа асуулаа.

“Та хоёр айн гээд сонсож бай даа. Хөвгүүд зүгээр байж байхад ирээд мөргөх, цохих юм бол надад ч гэсэн онцгүй аймар санагдана. Тэрийг бол ээж нь ойлгож байна. Харин үсний засалт, нүүр царай, зан ааш нь хачин гэвэл надад онцгүй санагдаж байна. Хэрэв та нар ямар нэг буруу зүйл хийгээд, бусдад шүүмжлүүлбэл ээж нь тэрийг тэвчиж бол чадна. Хойшид анхаарч, аль болох засахыг хичээж, уучлалт гуйж чадна. Харин хэн нэгэн та хэдийн үс, хувцас, царай төрхийг онцгүй, зан чанар нь хачин гэвэл надад маш онцгүй, гунигтай санагдана. Яагаад гэхээр ээжийнх хувьд та нар энэ дэлхий дээрх хамгийн хөөрхөн хүүхдүүд. Тэрэгтэй ижилхэн ямар ч хүүхдийн ард өөрийнхөө хүүхдийг хамгийн хөөрхөн гэж боддог ээж байгаа.”

Миний яриаг сонссон хоёр охин маань нүдэндээ нулимс цийлэгнүүлэн над руу ойртож ирлээ.

“Хүний дургүй хүргэсэн зүйл хийдэг хүн” гэж байдаг боловч, “хүний дургүй хүргэмээр хүн” гэж байхгүй. Ямар ч хүнд заавал ээж байдаг. Өөрийгөө хайрлуулж байгаагаа мэдэрч чадвал бусад хүнийг ч өөртэйгээ ижилхэн үнэ цэнтэй нэгэн гэдгийг ойлгож чадна. Охидууддаа ийнхүү сургамжилж байхдаа, би өөрөө ч бусдыг харахдаа ийм халуун сэтгэлээр харах ёстой юм байна гэж бодогдов.

“Ээжээ танд хайртай шүү” “Ээж нь ч гэсэн. Та нар чинь ээжийнхээ хувьд дэлхий дээрх хамгийн хөөрхөн хүүхдүүд шүү дээ!”. Дөнгөж сэрсэн нойрмог царай, дарж



Нивано Коошоо

Рисшо Косей Кай байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуульч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараа тус байгууллагын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Судрыг судлан суралцахын хажуугаар гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтрах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн тус байгууллагын удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

унгаад буржийсан үс, сонин инээдэг нь гээд бүх зүйл нь хөөрхөн!” “Яанаа ичмээр юмаа!” “За хүүхдүүдээ бэлтгэлээ хангаарай”
“Заа!”

Шинэ өдөр эхэлж байна шүү дээ.

“Якүшин” 2010 оны 12-р сарын дугаараас

Олон улсын хэлтсийн даргын булан



Эрүүл, жаргалтай байхын нууц нь юу вэ?

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу? 2023 он дуусахад хэдхэн хоног үлдлээ. Нивано ерөнхийлөгч энэ жилийн туршид сургаал, номлолоороо дамжуулан бид бүгдэд эрүүл энх, аз жаргалтай амьдралыг ерөөн залбирсан билээ. Оны төгсгөлийн энэхүү дугаараар бид 『Хэзээд сэргэлэн цовоо бай. Өвчин, зовлон ч гэсэн бидний сайн нөхөр』 гэсэн айлдварыг хүлээн авлаа.

Цагаан Лянхуа сударт “Дэвадатаас авахуулаад өвчин зовлон, гамшиг зэрэг бүхий л зүйлс нь жинхэнэ үнэнийг олж харах боломж” гэж үзэн хүлээн авахыг зааж сургасан байдаг.

Гэсэн хэдий ч бид заримдаа [эрүүл мэнд ба өвчин] [гамшиг зовлон ба аз завшаан] [зовлон зүдгүүр ба ая тух] [талархал ба зүй ёс] зэрэг 2 талт үнэлэмжээр харилцаанд орох хандлагатай байдаг.

Эрүүл саруул, тайван амьдрахыг хүсдэггүй хүн байхгүй билээ. Үүний тулд [Дэвадат бол миний сайн нөхөр] гэж ойлгох мэдрэмжийг төлөвшүүлж, аливаа саад бэрхшээлийг даван туулах нууц нь өөрийн [Зүрх сэтгэлээ хөгжүүлэх] явдал гэдгийг энэхүү айлдвар дахин нотоллоо.

Он дуусах дөхөж байгаа энэ үед би эгогооэн тэргүүнд тавьдаг сэтгэлийн зуршлаа нягталж, жам ёсыг хүлээн зөвшөөрсөн талархлын сэтгэлийн үндсийг сэтгэлдээ бат бөхөөр ургуулж, цаашид улам илүү хичээн зүтгэх болно гэдгээ амлаж байна.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers

facebook

twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp